



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөгшөө” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2022/16/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2022 он

Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:  
Эн Ай Ти Эс баланс аудит ХХК  
Захирал: Ш.Ичинхорлоо  
Утас: 99102291 Цахим хаяг: [tavanchuluu.ts@moaudit.com](mailto:tavanchuluu.ts@moaudit.com)



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

Г УРВАНТЭС СУМЫН “ХӨГШӨӨ”  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Л.ТӨМӨРТӨГТОХ  
ТАНАА

2022.03.24 № 270

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурвантэс сумын “Хөгшөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Гурвантэс сумын “Хөгшөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон зүйл**

Тайлант онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр шинээр ашиглалтад орсон автозам, талбай, гэрэлтүүлэг зэрэг 1,748.2 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг зам арчилгааны үйлчилгээ хариуцдаггүй, мэргэжлийн бус, дулааны үйлдвэрлэл эрхэлж буй “Хөгшөө” ОНӨААТҮГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлсэн байна.

**Аудитын гол асуудлууд**

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолын хүрээнд тайлант хугацааны 72.4 сая, өмнөх оны санхүүжилтийн үлдэгдэл 10.0 сая, нийт 82.4 сая төгрөгийн дулааны төлбөрийн санхүүжилт авахаар тооцож, гүйцэтгэлээр 69.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үлдэгдэл 12.7 сая төгрөгийг авлагын дансанд бүртгэсэн байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудал**

Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор эрчим хүч, дулааны үнэ тарифыг шинэчлэн тогтоосон байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

019923444



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  С.ЦЭРЭНБАЯР



## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	74.5	88.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	845.8	3,094.8
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>920.3</b>	<b>3,183.5</b>
	Нийт өр төлбөрийн дүн	383.4	2,663.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	536.9	519.6
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>920.3</b>	<b>3,183.5</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	285.6	285.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	320.2	300.8
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(22.2)</b>	<b>(17.2)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(22.2)</b>	<b>(17.2)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559.1	536.9
	Тайлант оны үр дүн	(22.2)	(17.2)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>536.9</b>	<b>519.6</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	320.2	318.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		318.7
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>		<b>106.0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>		
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>106.0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,073.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		4,179.9
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>384.5</b>	<b>364.1</b>
	Урсгал зардал	384.5	364.1
	Хөрөнгийн зардал		
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>370.8</b>	<b>350.9</b>
	Улсын төсвөөс санхүүжих	370.8	350.9
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

### Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Хөгшөө” ОНӨААТҮГ нь эрхэм зорилгоо үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэх шинэ шатанд гаргахын тулд дулаан хангамжийн шилдэг технологийг нэвтрүүлэх болон хүчин чадлаа нэмэгдүүлэх, цахилгааны найдвартай эх үүсвэрт холбогдох, дулааны төвлөрсөн системд аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийг холбож орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж хүний хөгжил дээдэлсэн, байгаль орчинд ээлтэй жишиг компани болох гэж тодохойлжээ. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна.



## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

“Хөгшөө” ОНӨААТҮГ-ын дүрмийг Өмнөговь аймгийн Засаг дарга 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

“Хөгшөө” ОНӨААТҮГ дарга нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Компанийн тухай хууль” болон бусад хууль, тогтоомжийг үндэслэн Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулан ажиллаж байна.

### **Дөрөв. Аудитын гол асуудал**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хөгшөө” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, балансын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, хоёр дахь шатны чанарын хяналтыг ТАГ-ын аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нэр тус тус хэрэгжүүлсэн.

“Хөгшөө” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь 2021 оны санхүүгийн тайлангаа хооронд “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-д 2022 оны 01 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.



“Хөгшөө” ОНӨААТҮГ нь тайлант онд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Мөн гүйлгээ бүрийн анхан шатны баримтыг түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарын хамт байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, өмнө оны алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэх.

### **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр сумын Засаг тушаал гарган үйл ажиллагааны чиглэл нь хамааралгүй, мэргэжлийн бус байгууллагад өндөр өртөгтэй бүхий автозам, байгууламж, гэрэлтүүлгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгүүлсэн шалтгаан, үр дагаврыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзлээ.

#### **Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 714.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 84.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 629.6 сая төгрөгийн алдаанд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 714.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг түвшинээс их байгаа ч санхүүгийн тайлагналд нөлөөлөхгүй учир Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

#### **7.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:**

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хөгшөө ОНӨААТҮГ	6	714.5					3	84.9	3	629.6
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>6</b>	<b>714.5</b>					<b>3</b>	<b>84.9</b>	<b>3</b>	<b>629.6</b>